



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 15 сарын 29 өдөр

Дугаар 1/89

Улаанбаатар хот

### Нийслэлийн ерөнхий боловсролын 113 дугаар сургуулийн хөрөнгийг данснаас дансанд шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан 5,100,000.00 (таван сая нэг зуун мянган) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 113 дугаар сургууль (С.Энхтуяа)-д зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 113 дугаар сургууль (С.Энхтуяа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500337

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны дүгээр сарын -ны өдрийн дугаар тушаалын хавсралт



Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 113-р сургууль

№	Хөрөнгийн нэр	Марк дугаар	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн анхны үнэ		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр		
								Нэгж үнэ	Нийт үнэ			шилжүүлэх данс	бүртгэх данс	
1	Ус цэвэршүүлэгч	Хятад	2021	2022.12.31	сайн	ш	6	850,000	5,100,000			Бараа материал	Машин тоног төхөөрөмж	
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн											-	-		